



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/323

Хэрлэн сум

Зөвлөн туслах ажилд зориулж,  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар хуралдааны 10 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн аймгийн сургалтыг зохион байгуулах” ажлын хүрээнд анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа үүрэг хүлээгчдэд сэтгэл зүйн зөвлөн туслах ажилд 4,764,000 (дөрвөн сая долоон зуун жаран дөрвөн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүүхдэд ээлтэй орон нутаг болно үйл ажиллагааны зардлаас 1,769,200 (нэг сая долоон зуун жаран есөн мянга хоёр зуу), хүүхэд хамгаалах жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлаас 2,994,800 (хоёр сая есөн зуун ерэн дөрвөн мянга найман зуу) төгрөгийг санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



06 Аймгийн Засаг даргын 2022 оны  
17 дугаар сарын 17-ны өдрийн  
А/323 захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Сэтгэл зүйн зөвлөн туслах ажлын үйл ажиллагааны зардал	8*6 цаг	90000	4.320.000
2	Баннер хийх зардал	4ш	111000	444,000
	Дүн			4.764.000